САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

# ДААТГАЛЫН САЛБАРЫН 2016 ОНЫ 1ДҮГЭЭР УЛИРЛЫН НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2016 оны 6 дугаар сар

**ГАРЧИГ**

1**. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ** 2

1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 2

1.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ 2

1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ 4

1.4. ДААТГАЛЫН ХУРААМЖ 5

1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР _7

1.6. ДААТГАЛЫН НӨӨЦ САН 8

1.7. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА 9

1.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА 10

1.9. ДАВХАР ДААТГАЛ 11

2**. ЕРДИЙН ДААТГАЛ** 11

2.1. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ 12

2.2. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ 12

2.3. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ 12

0. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР 13

2.4. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА 13

2.5. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ 13

3**. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ** 14

3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ 14

3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР 14

3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ 15

3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА 15

4**. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ** 16

**5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ** 17

5.1. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ 17

5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ 18

6**. ДҮГНЭЛТ** 19

# 1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

## 1.1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2016 оны 1 дүгээр улирлын байдлаарердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 39, даатгалын хохирол үнэлэгч 29 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.Мөн даатгалын компанийн 242 салбар, 9 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 201 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 49 салбар, 2 төлөөлөгчийн газар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт-1

**Даатгалын зах зээл дээрх тусгайзөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

| № | | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016-I |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ердийн даатгалын компани | 17 | 16 | 16 | 15 | 15 |
| 2 | Урт хугацааны даатгалын компани | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 3 | Давхар даатгалын компани | | | | 1 | 1 |
| 4 | Даатгалын төлөөлөгч | 2357 | 3187 | 3260 | 3340 | 2976 |
| 5 | Даатгалын зуучлагч | 17 | 20 | 30 | 37 | 37 |
| 6 | Даатгалын хохирол үнэлэгч | 9 | 14 | 20 | 27 | 29 |
| 7 | Актуарч | 18 | 15 | 15 | 15 | 15 |
| | **БҮГД** | **2419** | **3253** | **3244** | **3436** | **3076** |

Хүснэгт-2

**Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо**

| № | | 2014 | 2015 | 2016-I |
|---|---|---|---|---|
| 1 | Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар | 254 | 255 | 251 |
| 2 | Даатгалын зуучлагч компанийн салбар | 135 | 174 | 201 |
| 3 | Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар | 42 | 52 | 51 |
| | **БҮГД** | **431** | **481** | **503** |

***2016оны 1 дүгээр улиралд:***Хорооны 2016 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 55 дугаар тогтоолоор“Мөнх эстимэйт” ХХК-д, мөн өдрийн 56 дугаар тогтоолоор “Үнэлгээ консалтинг” ХХК-д тус тус даатгалын хохирол үнэлгээний чиглэлээрүйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосонбайна.

## 1.2.ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Тайлант хугацаанддавхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ188.9тэрбум төгрөгбайгаань 2015оны 1 дүгээр улиралтай харьцуулахад18.7 тэрбумтөгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нийт хөрөнгийн өсөлт нь өмнөх оны мөн үеэс20 буюу түүнээс дээш хувиар өссөн 4 компанийн хөрөнгийн өсөлт нөлөөлжээ. Гэвч энэхүү тайлант хугацааны нийт хөрөнгийн өсөлтийг сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын нийт хөрөнгийн дундаж өсөлттэй харьцуулахад2.5 дахин бага байна.

График-1




Салбарын хэмжээнднийт хөрөнгөд эзлэх хувиар авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.4хувь, давхар даатгалын компани 15.5 хувь, урт хугацааны даатгалын компани 4.1хувийг эзэлж байна. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө, салбарт эзлэх хувийг дараах график болон хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

График-2




Хүснэгт-3

**Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ**

| № | Компани | Нийт хөрөнгийн дүн | | Өсөлт /бууралт/ |
|---|---|---|---|---|
| | | 2015.03.31 | 2016.03.31 | |
| 1 | Ард даатгал | 8,404,853,502.61 | 8,811,926,561.94 | 4.8% |
| 2 | Бодь даатгал | 11,188,241,511.83 | 17,149,632,796.01 | 53.3% |
| 3 | Ган зам даатгал | 5,036,142,300.10 | 5,709,467,512.06 | 13.4% |
| 4 | Гэр даатгал | 4,508,706,876.86 | 5,098,963,931.97 | 13.1% |
| 5 | Мандал женерал даатгал | 9,416,683,704.51 | 13,288,833,995.71 | 41.1% |
| 6 | Миг даатгал | 9,544,787,174.38 | 10,354,167,698.62 | 8.5% |
| 7 | Монгол даатгал | 28,809,876,594.97 | 28,418,376,484.73 | -1.4% |
| 8 | Монре даатгал | 5,550,241,347.95 | 5,930,396,545.93 | 6.8% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Мөнх даатгал | 4,161,246,581.00 | 4,269,470,314.00 | 2.6% |
| 10 | Номин даатгал | 7,499,079,004.98 | 8,645,970,121.17 | 15.3% |
| 11 | Нэйшнл лайф даатгал | 6,713,606,864.94 | 7,665,204,714.80 | 14.2% |
| 12 | Практикал даатгал | 9,061,978,939.67 | 9,554,281,369.27 | 5.4% |
| 13 | Соёмбо даатгал | 8,985,199,832.17 | 9,038,046,893.23 | 0.6% |
| 14 | Тэнгэр даатгал | 11,063,621,249.34 | 13,354,552,875.18 | 20.7% |
| 15 | Улаанбаатар хотын даатгал | 5,130,832,302.98 | 5,573,889,030.07 | 8.6% |
| 16 | Хаан даатгал | 6,370,314,442.37 | 6,727,466,909.10 | 5.6% |
| 17 | Хөдөө аж ахуйн давхар даатгал | 23,258,393,079.21 | 29,292,409,124.34 | 25.9% |
| | **НИЙТ** | **170,198,613,823.19** | **188,883,056,878.13** | **11.0%** |

## 1.3.ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2016 оны 1дүгээр улирлын байдлаардаатгалынболон давхар даатгалынкомпаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 23.5 тэрбум төгрөгөөр буурч, өр төлбөр 35.3 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 6.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

График-3




Хүснэгт-4

| Үзүүлэлтүүд | 2015-I | | 2016-I | | Өсөлт /бууралт/ |
|---|---|---|---|---|---|
| | төгрөгөөр | эзлэх хувь | төгрөгөөр | эзлэх хувь | төгрөгөөр |
| Өр төлбөр | 9,566,937,390.6 | 5.6% | 44,834,769,916.9 | 23.7% | 35,267,832,526.3 |
| Нөөц сан | 69,814,895,736.9 | 41.0% | 46,288,338,474.3 | 24.5% | -23,526,557,262.6 |
| Эзэмшигчийн өмч | 90,816,780,695.6 | 53.4% | 97,759,948,486.9 | 51.8% | 6,943,167,791.2 |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | **170,198,613,823.2** | **100.0%** | **188,883,056,878.1** | **100.0%** | **18,684,443,054.9** |

Хүснэгт-5

**Даатгалынболон давхар даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч**

| № | Компани | Нийт төлбөр | | Эзэмшигчдийн өмч | Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч |
|---|---|---|---|---|---|
| | | Өр төлбөр | Нөөц сан | | |
| 1 | **Ард даатгал** | 3,632,911,962.6 | 1,592,957,532.4 | 3,586,057,066.9 | 8,811,926,561.9 |
| 2 | **Бодь даатгал** | 9,660,928,897.7 | 2,421,783,223.1 | 5,066,920,675.2 | 17,149,632,796.0 |
| 3 | **Ган зам даатгал** | 380,793,024.2 | 694,157,500.8 | 4,634,516,987.0 | 5,709,467,512.1 |
| 4 | **Гэр даатгал** | 283,840,290.5 | 694,724,099.4 | 4,120,399,542.0 | 5,098,963,931.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | **Мандал женерал даатгал** | 6,477,344,699.2 | 2,313,057,711.3 | 4,498,431,585.2 | 13,288,833,995.7 |
| 6 | **Миг даатгал** | 3,187,163,938.7 | 1,835,015,765.0 | 5,331,987,994.9 | 10,354,167,698.6 |
| 7 | **Монгол даатгал** | 7,118,485,098.6 | 11,157,642,522.3 | 10,142,248,863.9 | 28,418,376,484.7 |
| 8 | **Монре даатгал** | 1,389,807,010.8 | 460,628,692.7 | 4,079,960,842.4 | 5,930,396,545.9 |
| 9 | **Мөнх даатгал** | 158,228,831.0 | 389,342,774.0 | 3,721,898,709.0 | 4,269,470,314.0 |
| 10 | **Номин даатгал** | 1,735,950,199.5 | 3,232,502,144.0 | 3,677,517,777.7 | 8,645,970,121.2 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 24,895,133.4 | 1,476,818,959.7 | 6,163,490,621.7 | 7,665,204,714.8 |
| 12 | **Практикал даатгал** | 2,764,236,737.4 | 2,343,508,668.7 | 4,446,535,963.2 | 9,554,281,369.3 |
| 13 | **Соёмбо даатгал** | 2,016,107,588.0 | 1,820,342,026.1 | 5,201,597,279.2 | 9,038,046,893.2 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 3,863,498,671.8 | 3,587,100,241.9 | 5,903,953,961.4 | 13,354,552,875.2 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 374,103,302.7 | 891,463,375.0 | 4,308,322,352.3 | 5,573,889,030.1 |
| 16 | **Хаан даатгал** | 1,731,549,239.7 | 751,236,590.6 | 4,244,681,078.9 | 6,727,466,909.1 |
| 17 | **Хөдөө аж ахуйн давхар даатгал** | 34,925,291.1 | 10,626,056,647.4 | 18,631,427,185.9 | 29,292,409,124.3 |
| | **Нийт** | 44,834,769,916.9 | 46,288,338,474.3 | 97,759,948,486.9 | 188,883,056,878.1 |

## 1.4.ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 230871 иргэд, албан байгууллагуудтай даатгалын гэрээ байгуулж, 27.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн нийт орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын хураамжийн нийт орлогын 98.9 хувь буюу 26.9тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.1 хувь буюу 0.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниуд даатгалын хураамжийн нийт орлогынхоо 48.2 хувийг давхар даатгалын хураамжид зарцуулжээ.Энэхүү тайлант хугацааны даатгалын хураамжийн нийт орлого нь өмнөх оны мөн үеэс23.4 хувиар буурсан байна.

График-4




Хүснэгт-6

**Даатгалынкомпаниудын төвлөрүүлсэн даатгалын хураамж**

| № | Даатгалын компани | Даатгалын хураамжийн нийт орлого | Давхар даатгалын хураамжийн зардал | Даатгалын хураамжийн буцаалт | Даатгалын хураамжийн цэвэр орлогын дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Ард даатгал** | 1,199,364,583.8 | 138,957,979.1 | 32,550,804.3 | 1,027,855,800.4 |
| 2 | **Бодь даатгал** | 10,241,743,835.5 | 9,257,255,995.6 | 42,023,625.5 | 942,464,214.4 |
| 3 | **Ган зам даатгал** | 32,204,746.0 | 0 | 0 | 32,204,746.0 |
| 4 | **Гэр даатгал** | 41,407,278.0 | 0 | 1,569,630.0 | 39,837,648.0 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 2,221,599,398.6 | 1,227,851,014.2 | 32,355,974.8 | 961,392,409.7 |
| 6 | **Миг даатгал** | 2,051,916,279.0 | 0 | 59,222,838.4 | 1,992,693,440.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | **Монгол даатгал** | 4,630,969,191.3 | 1,862,027,092.1 | 66,281,501.3 | 2,702,660,598.0 |
| 8 | **Монре даатгал** | 685,458,589.6 | 0 | 38,284,046.9 | 647,174,542.7 |
| 9 | **Мөнх даатгал** | 107,537,101.0 | 0 | 0 | 107,537,101.0 |
| 10 | **Номин даатгал** | 842,767,752.5 | 123,963,208.0 | 42,679,618.7 | 676,124,925.8 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 303,018,442.6 | 9,124,180.0 | 0 | 293,894,262.6 |
| 12 | **Практикал даатгал** | 1,479,291,409.4 | 138,976,425.0 | 36,977,801.0 | 1,303,337,183.4 |
| 13 | **Соёмбо даатгал** | 809,244,212.5 | 57,415,637.6 | 18,945,222.9 | 732,883,352.1 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 1,234,430,901.7 | 277,197,390.3 | 33,007,714.4 | 924,225,797.0 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 120,027,598.0 | 0 | 317,500.0 | 119,710,098.0 |
| 16 | **Хаан даатгал** | 1,232,301,022.2 | 28,349,996.6 | 10,190,893.5 | 1,193,760,132.2 |
| | **НИЙТ** | 27,233,282,341.7 | 13,121,118,918.5 | 414,407,171.7 | 13,697,756,251.6 |

Тайлант хугацаанд даатгалын хураамжийн нийт орлогын дүн өмнөх оны мөн үеэс буурсантай холбоотой даатгалын хэлбэр тус бүрээр авч үзвэл хөрөнгийн даатгал, ачааны даатгал, мал амьтдын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар тус тус нийт хураамжийн орлогын дүн өссөн бөгөөд бусад даатгалын хэлбэрээр хураамжийн орлого буурсан үзүүлэлт ажиглагдлаа.Даатгалын хураамжийннийт орлогын бүтцэдхөрөнгийн даатгал 48.6 хувийг, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 19.2 хувийг эзэлж, 32.2 хувь нь бусад даатгалын хэлбэрт ногдож байна.

Хүснэгт-7

**Даатгалын хураамжийн нийт орлого /хэлбэрээр/**

| № | Даатгалын хэлбэр | Даатгалын хураамжийн нийт орлого | | Өсөлт, бууралт /хувиар/ |
|---|---|---|---|---|
| | | 2015.03.31 | 2016.03.31 | |
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | 2,887,316,126.0 | 2,211,550,390.4 | (23.4) |
| 2 | Хөрөнгийн даатгал | 7,359,471,084.3 | 13,237,618,283.1 | 79.9 |
| 3 | Авто тээврийн хэрэгслийн даатгал | 2,993,297,038.0 | 2,601,979,207.6 | (13.1) |
| 4 | Ачааны даатгал | 204,404,459.5 | 233,513,189.8 | 14.2 |
| 5 | Барилга угсралтын даатгал | 156,347,397.1 | 101,376,535.2 | (35.2) |
| 6 | Газар тариалангийн даатгал | - | - | - |
| 7 | Мал амьтдын даатгал | 8,449,125.0 | 19,865,022.0 | 135.1 |
| 8 | Агаарын хөлгийн даатгал | 867,917,950.3 | 361,780,725.9 | (58.3) |
| 9 | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 60,493,009.5 | 57,626,553.3 | (4.7) |
| 10 | Хариуцлагын даатгал | 1,573,241,556.8 | 1,578,442,264.7 | 0.3 |
| 11 | Санхүүгийн даатгал | 1,000,168,511.8 | 669,410,700.6 | (33.1) |
| 12 | Зээлийн даатгал | 326,610,895.7 | 194,350,467.1 | (40.5) |
| 13 | Итгэлцлийн даатгал | - | 15,871,851.4 | - |
| 14 | Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал | - | - | - |
| 15 | Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | - | - | - |
| 16 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 13,960,678,525.0 | 412,714,651.9 | - |
| 17 | Жолоочийн хариуцлагын даатгал | 3,627,637,070.1 | 5,234,164,056.2 | 44.3 |
| 18 | Хугацаат амьдралын даатгал | 134,110,655.2 | 30,761,900.1 | (77.1) |
| 19 | Насан туршийн даатгал | | | - |
| 20 | Хуримтлалын даатгал | 34,462,279.5 | 28,982,601.0 | (15.9) |
| 21 | Тэтгэврийн даатгал | 16,517,298.4 | 15,785,622.8 | (4.4) |
| 22 | Эрүүл мэндийн даатгал | 325,972,911.5 | 227,488,318.7 | (30.2) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 23 | Аннуити даатгал | - | - | - |
| | Дүн | 35,537,095,893.6 | 27,233,282,341.7 | (23.4) |

Тайлант хугацаанд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчдын даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт нь дараах байдалтай байна. Даатгалын хураамжийн орлого төвлүүлэлтийн энэхүү тоон мэдээллийг даатгалын компаниудын тайлангаас нэгтгэсэн болно.

График-5

**Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт**




## 1.5.ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд даатгалынкомпаниуд15560 иргэд, байгууллагуудад 8.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Үүнээс0.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг гадаадын давхар даатгагчаас хариуцсан байна. Даатгуулагчдад олгосон нийт нөхөн төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар буурч, харин нийт нөхөн төлбөрт эзлэх давхар даатгалаас олгосон нөхөн төлбөрийн хувь хэмжээ нь сүүлийн 5 жилийн дунджаас 2.5 дахин өссөн байна. Даатгалын компани тус бүрийн олгосон нөхөн төлбөрийн хэмжээ, сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын нийт нөхөн төлбөр зэргийг дараах хүснэгт болон графикт дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт-8

| № | Даатгалын компани | Нийт нөхөн төлбөр | | Өсөлт, бууралт /хувиар/ |
|---|---|---|---|---|
| | | 2015.03.31 | 2016.03.31 | |
| 1 | **Ард даатгал** | 883,358,180.06 | 666,242,457.42 | (24.6) |
| 2 | **Бодь даатгал** | 966,532,597.00 | 736,042,632.33 | (23.8) |
| 3 | **Ган зам даатгал** | 27,564,413.00 | 7,065,527.00 | (74.4) |
| 4 | **Гэр даатгал** | 17,094,791.00 | 22,027,133.00 | 28.9 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 340,274,929.77 | 1,105,206,540.98 | 224.8 |
| 6 | **Миг даатгал** | 899,838,456.00 | 1,201,190,032.70 | 33.5 |
| 7 | **Монгол даатгал** | 3,480,290,977.82 | 1,680,066,556.08 | (51.7) |
| 8 | **Монре даатгал** | 462,551,778.00 | 552,895,058.00 | 19.5 |
| 9 | **Мөнх даатгал** | 18,893,334.00 | 4,041,669.00 | (78.6) |
| 10 | **Номин даатгал** | 448,330,149.00 | 312,228,753.00 | (30.4) |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 218,866,792.00 | 212,985,583.40 | (2.7) |
| 12 | **Практикал даатгал** | 512,562,808.00 | 759,237,010.00 | 48.1% |
| 13 | **Соёмбо даатгал** | 310,443,435.12 | 512,382,298.92 | 65.0% |
| 14 | **Тэнгэр даатгал** | 602,544,385.65 | 596,374,022.13 | (1.0) |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 14,988,771.00 | 23,134,851.00 | 54.3% |
| 16 | **Хаан даатгал** | 168,581,412.00 | 183,966,581.00 | 9.1% |
| | **НИЙТ** | **9,372,717,209.4** | **8,575,086,706.0** | (8.5) |

График-6




Тайлант хугацаанд олгосон нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл нийт нөхөн төлбөрийн 50.3 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 23.9 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал тус тус эзэлж, 2.8 хувь нь бусад даатгалын хэлбэрт ногдож байна.

Хүснэгт-9

| № | Даатгалын хэлбэр | Нөхөн төлбөр | |
|---|---|---|---|
| | | **2015.03.31** | **2016.03.31** |
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | 682,449,297.0 | 672,587,998.8 |
| 2 | Хөрөнгийн даатгал | 547,237,841.6 | 621,269,291.2 |
| 3 | Автотээврийн хэрэгслийн даатгал | 2,228,367,558.2 | 2,051,960,164.7 |
| 4 | Ачааны даатгал | 44,831,513.6 | 16,295,249.8 |
| 5 | Барилга угсралтын даатгал | - | 5,706,880.0 |
| 6 | Мал амьтдын даатгал | 6,422,400.0 | 25,689,600.0 |
| 7 | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 3,765,433.0 | 7,934,900.0 |
| 8 | Хариуцлагын даатгал | 123,185,257.4 | 133,430,221.0 |
| 9 | Санхүүгийн даатгал | 260,405,206.6 | 344,637,654.7 |
| 10 | Зээлийн даатгал | 1,866,266,978.4 | 5,298,343.3 |
| 11 | Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал | - | 3,788,530.3 |
| 12 | Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | - | 155,855,193.5 |
| 13 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 3,175,971.8 | 1,035,000.0 |
| 14 | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 3,752,481,816.4 | 4,316,612,095.3 |
| 15 | Хугацаат амьдралын даатгал | 24,109,956.0 | 21,279,579.0 |
| 16 | Хуримтлалын даатгал | 16,545,415.0 | 26,106,874.0 |
| 17 | Тэтгэврийн даатгал | 13,079,750.0 | 2,876,141.0 |
| 18 | Эрүүл мэндийн даатгал | 165,131,671.0 | 162,722,989.4 |
| | Дүн | **9,737,456,066.0** | **8,575,086,706.0** |

Жич: Тайлант хугацаанд нөхөн төлбөр олгогдоогүйдаатгалын хэлбэрүүдийг дээрххүснэгтэд оруулаагүй болно.

## 1.6.ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Тайлант хугацаанд даатгалынкомпаниудын нөөц сангийн хэмжээ 35.7 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 43.2 хувиар буурсан байна.Санхүүгийн зохицуулах хорооноос “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн ердийн даатгалын компаниуд тус журмыг мөрдөж эхэлснээс хамаарч нөөц сангийн хэмжээ буурсан. Уг журмаар

зохицуулснаар нөөц сангийн хэмжээ багасч байгаа боловч нийт өр төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орохгүйгээр нөөц сангийн бууруулсан дүнг компанийн тусгай нөөцөд бүртгэж байгаа юм. Энэхүү тайлант хугацааны нөөц сангийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ердийн даатгалын 15 компанийнх буурч, "Нэйшнл лайф даатгал" ХХК-ийнх 4 орчим хувиар өссөн байна.

График-7




## 1.7.ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хохирлын харьцаа нь 26.9 хувьтай байна. Энд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг нэмж тооцсон болно. Мөн даатгагчийн орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 42.4 хувьтай байна.Даатгалын компаниудын хохирол нөхөлт болон сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын хохирлын харьцааг график, хүснэгтээр дэлгэрэнгүй харуулав.

График-8




Хүснэгт-10

**Даатгалын компаниудын хохирлын харьцаа**

| № | Даатгалын компани | Нийт орлогод тооцсон хураамж | Даатгагчаас олгосон нөхөн төлбөр | Хохирлын харьцаа |
|---|---|---|---|---|
| 1 | **Ард даатгал** | 1,479,803,251.0 | 666,242,457.4 | 45.0% |
| 2 | **Бодь даатгал** | 2,710,266,898.7 | 736,042,632.3 | 27.2% |
| 3 | **Ган зам даатгал** | 127,836,923.6 | 7,065,527.0 | 5.5% |
| 4 | **Гэр даатгал** | 107,134,013.3 | 22,027,133.0 | 20.6% |
| 5 | **Мандал женерал даатгал** | 880,915,155.7 | 499,684,307.1 | 56.7% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | **Миг даатгал** | 2,233,070,162.3 | 1,178,573,298.5 | 52.8% |
| 7 | **Монгол даатгал** | 4,061,900,166.7 | 1,680,066,556.1 | 41.4% |
| 8 | **Монре даатгал** | 689,098,802.8 | 552,895,058.0 | 80.2% |
| 9 | **Мөнх даатгал** | 225,554,738.0 | 4,041,669.0 | 1.8% |
| 10 | **Номин даатгал** | 894,332,297.3 | 312,228,753.0 | 34.9% |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 293,894,262.6 | 212,985,583.4 | 72.5% |
| 12 | **Практикал даатгал** | 1,102,788,385.2 | 759,237,010.0 | 68.8% |
| 13 | **Соёмбо даатгал** | 1,129,900,958.3 | 512,382,298.9 | 45.3% |
| 14 | **Тэнгэр даатгал** | 1,647,082,877.4 | 590,569,656.3 | 35.9% |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 193,438,313.0 | 23,134,851.0 | 12.0% |
| 16 | **Хаан даатгал** | 964,095,792.4 | 183,966,581.0 | 19.1% |
| | Нийт | **18,741,112,998.0** | **7,941,143,372.1** | **42.4%** |

Хүснэгт-11

**Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг оруулж тооцсон хохирлын харьцаа**

| № | Даатгалын компани | Нийт орлогод тооцсон хураамж+Давхар даатгалын хураамж | Нийт нөхөн төлбөр | Хохирлын харьцаа |
|---|---|---|---|---|
| 1 | **Ард даатгал** | 1,618,761,230.2 | 666,242,457.4 | 41.2% |
| 2 | **Бодь даатгал** | 11,967,522,894.3 | 736,042,632.3 | 6.2% |
| 3 | **Ган зам даатгал** | 127,836,923.6 | 7,065,527.0 | 5.5% |
| 4 | **Гэр даатгал** | 107,134,013.3 | 22,027,133.0 | 20.6% |
| 5 | **Мандал женерал даатгал** | 2,108,766,169.9 | 1,105,206,541.0 | 52.4% |
| 6 | **Миг даатгал** | 2,233,070,162.3 | 1,201,190,032.7 | 53.8% |
| 7 | **Монгол даатгал** | 5,923,927,258.7 | 1,680,066,556.1 | 28.4% |
| 8 | **Монре даатгал** | 689,098,802.8 | 552,895,058.0 | 80.2% |
| 9 | **Мөнх даатгал** | 225,554,738.0 | 4,041,669.0 | 1.8% |
| 10 | **Номин даатгал** | 1,018,295,505.3 | 312,228,753.0 | 30.7% |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 303,018,442.6 | 212,985,583.4 | 70.3% |
| 12 | **Практикал даатгал** | 1,241,764,810.2 | 759,237,010.0 | 61.1% |
| 13 | **Соёмбо даатгал** | 1,187,316,595.9 | 512,382,298.9 | 43.2% |
| 14 | **Тэнгэр даатгал** | 1,924,280,267.8 | 596,374,022.1 | 31.0% |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 193,438,313.0 | 23,134,851.0 | 12.0% |
| 16 | **Хаан даатгал** | 992,445,789.0 | 183,966,581.0 | 18.5% |
| | **Нийт** | **31,862,231,916.6** | **8,575,086,706.0** | **26.9%** |

## 1.8.ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд даатгалын болон давхар даатгалын компаниудын цэвэр ашиг 3.9 тэрбум төгрөг, хуримтлагдсан ашиг 10 тэрбум төгрөг бөгөөд тайлант хугацааны цэвэр ашиг нь өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

| Хүснэгт -12№ | Даатгалын компани | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | | |
|---|---|---|---|---|
| | | **2015.03.31** | **2016.03.31** | **Өсөлт /бууралт/** |
| 1 | **Ард даатгал** | 80,964,115.87 | (225,315,522.48) | (306,279,638.4) |
| 2 | **Бодь даатгал** | (746,770,769.72) | 964,298,389.13 | 1,711,069,158.9 |
| 3 | **Ган зам даатгал** | 158,422,310.15 | 253,774,475.34 | 95,352,165.2 |
| 4 | **Гэр даатгал** | 82,899,989.45 | 166,906,155.96 | 84,006,166.5 |
| 5 | **Мандал женерал даатгал** | (7,288,061.87) | (314,685,977.33) | (307,397,915.5) |
| 6 | **Миг даатгал** | (226,249,550.50) | 1,580,574,217.60 | 1,806,823,768.1 |
| 7 | **Монгол даатгал** | 141,992,240.78 | 46,983,029.25 | (95,009,211.5) |
| 8 | **Монре даатгал** | 3,677,763.43 | 17,891,714.96 | 14,213,951.5 |
| 9 | **Мөнх даатгал** | 1,979,816.00 | 3,184,748.00 | 1,204,932.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | **Номин даатгал** | (22,063,052.56) | 42,738,525.76 | 64,801,578.3 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 107,770,973.12 | 16,733,203.96 | (91,037,769.2) |
| 12 | **Практикал даатгал** | 98,421,836.43 | 7,030,974.05 | (91,390,862.4) |
| 13 | **Соёмбо даатгал** | 114,652,294.51 | 200,470,749.83 | 85,818,455.3 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 251,468,331.62 | 537,168,627.07 | 285,700,295.5 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 22,490,431.83 | 54,124,647.75 | 31,634,215.9 |
| 16 | **Хаан даатгал** | 203,069,155.17 | 139,230,787.37 | (63,838,367.8) |
| 17 | **ХАА-н давхар даатгал** | 1,245,699,853.06 | 393,648,753.25 | (852,051,099.8) |
| | **НИЙТ** | 1,511,137,676.8 | 3,884,757,499.5 | 2,373,619,822.7 |

График-9

**Тайлант хугацааны цэвэр ашиг /тэрбум төгрөг/**




1.9.<u>ДАВХАР ДААТГАЛ</u>

Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 13.1 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төлсөн нь даатгалын хураамжийн нийт орлогын 48.2 хувийг эзэлж байна.“Бодь даатгал” ХХК-ийн хувьд давхар даатгалд төлсөн хураамж нь хураамжийн нийт орлогынхоо90.4 хувийг, “Мандал женерал даатгал” ХХК-ийн хувьд 55.3 хувийг, “Монгол даатгал” ХХК-ийн хувьд 40.2 хувийг, “Тэнгэр даатгал” ХХК-ийн хувьд 22.5 хувийг эзэлж байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд хүчтэй нөлөөлж байна. Тайлантхугацаанд давхар даатгагчаас 0.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 8 орчим хувийг эзэлж байна.Сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын байдлаарх давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг дараах графикаар харуулав.

График-10

**Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөг/**




2. <u>ЕРДИЙН ДААТГАЛ</u>

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 15 ердийн даатгалын компани, тэдгээрийннийт 241 салбар, 9 төлөөлөгчийн газар Улаанбаатар хотболон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

## 2.1.ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ

Ердийн даатгалын 15 компанийн нийт хөрөнгийн хэмжээ тайлант хугацаанд 151.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 11.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын байдлаархердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийг график-12-т харуулав.

График-11




## 2.2. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн эзлэх хувийг дараах графикаар харуулав. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн талаар1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

График-12

**Ердийн даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч**




## 2.3.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 14даатгалын хэлбэрээр 26.9 тэрбум төгрөгийн хураамж нийт орлого төвлөрүүлж, үүнээс давхар даатгалын хураамжид13.1 тэрбум төгрөг төлж,0.4 тэрбум төгрөгийн хураамжийг даатгуулагч нарт буцаан олгосноор 13.4 тэрбум төгрөгийн хураамжийн цэвэр орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, дараах графикаар харуулав.

График-13

**Ердийн даатгалын нийт хураамжийн орлогын бүтэц /хэлбэрээр/**




ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 8.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд энэ нь салбарын нийт нөхөн төлбөрийн 97.5 хувийг эзэлж байна.Нийт нөхөн төлбөрийн0.6 тэрбум төгрөгийгдавхар даатгагчаас,7.7тэрбум төгрөгийг даатгагч нараас төлсөн байна. Даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

2.4.ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА

Ердийн даатгалын компанийн хохирол нөхөлтийн харьцаа салбарын дунджаар 41.9 хувьтай байгаа бөгөөд давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг нэмж тооцсон хохирлын харьцаа салбарын дунджаар 26.5 хувь байна.Даатгагч нарын хохирлын харьцааны талаар 1.7 дахь хэсэгт дэлгэрэнгүй харуулав.

Ердийн даатгалын компаниудын тайлант хугацааны цэвэр ашиг 3.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.Компаниудын ашигт ажиллагааг 1.8 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын байдлаар тайлант хугацааны цэвэр ашиг, хуримтлагдсан ашгийг дараах графикаар харуулав.

График-14

**Ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагаа**




2.5.ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нөөц сан 34.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 27.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Ердийн даатгагчид өөрийн хүлээх эрсдэлийг хэсэгчлэн гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 13.1тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс

37 хувиар буурсан байна. Давхар даатгалын талаар 1.9 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

| Хүснэгт -13№ | Даатгалын компани | Давхар даатгалын хураамж | | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | | 2015.03.31 | 2016.03.31 | |
| 1 | **Ард даатгал** | 334,372,096.5 | 138,957,979.1 | -195,414,117.3 |
| 2 | **Бодь даатгал** | 14,791,678,648.6 | 9,257,255,995.6 | -5,534,422,653.0 |
| 3 | **Ган зам даатгал** | 0.0 | 0.0 | 0.0 |
| 4 | **Гэр даатгал** | 0.0 | 0.0 | 0.0 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 1,237,822,960.7 | 1,227,851,014.2 | -9,971,946.5 |
| 6 | **Миг даатгал** | 23,511,455.2 | 0.0 | -23,511,455.2 |
| 7 | **Монгол даатгал** | 3,797,004,966.3 | 1,862,027,092.1 | -1,934,977,874.2 |
| 8 | **Монре даатгал** | 13,356,040.2 | 0.0 | -13,356,040.2 |
| 9 | **Мөнх даатгал** | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10 | **Номин даатгал** | 91,709,792.0 | 123,963,208.0 | 32,253,416.0 |
| 11 | **Практикал даатгал** | 175,829,566.2 | 138,976,425.0 | -36,853,141.2 |
| 12 | **Соёмбо даатгал** | 0.0 | 57,415,637.6 | 57,415,637.6 |
| 13 | **Тэнгэр даатгал** | 354,454,531.5 | 277,197,390.3 | -77,257,141.1 |
| 14 | **Улаанбаатар хотын даатгал** | 0.0 | 0.0 | 0.0 |
| 15 | **Хаан даатгал** | 0.0 | 28,349,996.6 | 28,349,996.6 |
| | **НИЙТ** | **20,819,740,057.1** | **13,111,994,738.5** | **-7,707,745,318.6** |

## 3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

### 3.1.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийннийт хөрөнгийн хэмжээсүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өсөлттэй байгаа бөгөөд тайлант хугацаанд 7.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График-15

**Урт хугацааны даатгагчийн нийт хөрөнгө**




### 3.2.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн нийт орлого тайлант хугацаанд 0.3 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс0.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацааны нийт нөхөн төлбөр 0.2 тэрбум төгрөгт бөгөөд урт хугацааны даатгагчийн хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөрийн харьцаа 70.3 хувьтай

байна.Даатгалын хураамжийн нийт орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын дүнгээрхарьцуулав.

График-16




3.3.<u>УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ</u>

Давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 9.1 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.Урт хугацааны даатгалын сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлын давхар даатгалын хураамжийг графикаар харуулав.

График-17




3.4.<u>УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА</u>

Урт хугацааны даатгалын хураамжийн орлогын тогтмол өсөлттэй холбоотой даатгалын нөөц сангийн хэмжээ нь тогтмол өсч байна. Тайлант хугацаанд даатгагчийн нөөц сан 1.47 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 13.1 хувиар өссөн байна.

График-18




“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн тайлант хугацааны цэвэр ашиг 16.7 сая төгрөгт байна. Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагааг сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлынбайдлаар дараах графикаар харуулав.

График-19

**Урт хугацааны даатгагчийн цэвэр ашиг, алдагдал**




## 4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

2016оны 1 дүгээр улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид "жолоочийн хариуцлагын даатгал" гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж байна.Тайлант хугацаанд даатгагч нар жолоочийн хариуцлагын даатгалаар5.2 тэрбум төгрөгийнхураамжийн нийт орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалын 6296 тохиолдолд нийт 4.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын нийт хураамжийн орлого, нийт нөхөн төлбөрийг харьцуулж харуулав.

График-20

**2016 оны 1 дүгээр улирлын хураамжийн нийторлого, нийт нөхөн төлбөр/даатгалын**




Сүүлийн 3 жилийн 1 дүгээр улирлын статистикаас харахаджолоочийн хариуцлагын даатгалын 1 гэрээ тутамд ногдож буй даатгалын тохиолдлын тоо дараах байдалтай байна.

График-21

**ЖХАЖД-ын тохиолдол**



# 5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

## 5.1.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зуучлагч 37 компаниас 34 компанийн тайлан фина системд нэгтгэгдсэн бөгөөдүүнээс 7 компани даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулаагүй байна. Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж, Хороонд ирүүлсэн тайлан мэдээ нь нэгтгэгдсэн 27 компанийн тайлангаас үзэхэд нийт2.2 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий ердийн даатгалын 11, урт хугацааны даатгалын 1 бүтээгдэхүүнийг зуучилж,5.7тэрбум төгрөгийн даатгалын хураамжийнтөвлөрүүлсэн нь салбарын хураамжийн нийт орлогын 20.9 хувийг бүрдүүлж байна. Даатгалын зуучлалын орлого0.9 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График-22

**Даатгалын зуучлал /2016-I/**




Хүснэгт -14

| № | Даатгалын зуучлагч компани | 2015.03.31 | | 2016.03.31 | |
|---|---|---|---|---|---|
| | | **Зуучилсан даатгалын хураамжийн орлого** | **Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого** | **Зуучилсан даатгалын хураамжийн орлого** | **Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого** |
| 1 | Асимон брокерс | 453,300,166.8 | 44,751,906.8 | 982,811,128.7 | 45,262,807.7 |
| 2 | AME | 76,132,724.3 | 15,459,957.9 | 306,852,171.0 | 12,165,424.0 |
| 3 | Ай Ай Би | - | - | - | - |
| 4 | Ар Эм Ай Би | - | - | - | - |
| 5 | Ариг банк | 9,152,405,974.3 | 23,341,995.9 | 7,554,827.1 | 1,561,097.2 |
| 6 | Арм интернэшнл | - | - | - | - |
| 7 | Ачит ундарга | 101,377,279.7 | 24,798,548.2 | 38,994,001.5 | 6,160,640.1 |
| 8 | Ваясньюо Солюшн | 21,750,531.0 | 6,511,209.0 | 55,881,652.0 | 15,264,070.2 |
| 9 | Голомт банк | - | - | 321,973,529.0 | 46,137,885.0 |
| 10 | Гэрэлт буян ундрах | 163,039,709.0 | 48,425,950.0 | 74,633,785.0 | 20,163,747.0 |
| 11 | Дэвжих дэлгэрэх холдинг | 17,589,030.0 | 3,043,394.0 | 82,751,520.0 | 14,098,962.0 |
| 12 | Капитал банк | - | - | 71,325,455.3 | 9,194,697.2 |
| 13 | Лояалти солюшн | 164,654,205.0 | 51,323,700.0 | 21,663,881.0 | 6,705,590.0 |
| 14 | Мастер шийдэл | - | - | 347,925.0 | 0.0 |
| 15 | Монгол бичээч зууч | 4,237,373.0 | 1,271,211.9 | 36,733,385.0 | 7,676,578.9 |
| 16 | Монголиан интернэшнл брокерс | - | - | - | - |
| 17 | Монголиан иншуранс брокерейж | - | - | - | - |
| 18 | Нэйшнл эженси | 46,148,763.0 | 13,844,629.0 | 173,789,020.0 | 14,203,754.0 |
| 19 | Ренессанс групп | 14,265,103.1 | 3,395,599.0 | 1,736,560.0 | 332,956.5 |
| 20 | Си эн эн икс | 87,599,564.2 | 16,267,201.9 | 61,999,297.1 | 9,949,657.9 |

Хүснэгт -14№ Даатгалын зуучлагч компани

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | Соёомбо Ай Би | 583,425.0 | 175,027.5 | - | - |
| 22 | Сүрэг хараацай | 318,986,578.0 | 76,567,412.0 | 653,328,843.0 | 145,221,061.0 |
| 23 | Тод капитал | - | - | 90,506,401.0 | 15,233,541.8 |
| 24 | Төрийн банк | 172,548,845.9 | 39,257,739.3 | 466,094,965.5 | 97,325,588.5 |
| 25 | Тус брокерс | - | - | - | - |
| 26 | Түвшин ориент | - | - | - | - |
| 27 | Үндэсний хөрөнгө оруулалтын банк | 10,494,917.0 | 1,786,652.0 | 740,067,958.4 | 177,809,194.1 |
| 28 | Хаан банк | 759,885,273.0 | 154,211,949.0 | 500,758,092.0 | 100,134,498.0 |
| 29 | ХасБанк | 231,577,724.5 | 46,165,391.4 | 168,474,269.3 | 33,694,853.9 |
| 30 | Худалдаа хөгжлийн банк | 594,538,380.7 | 80,006,470.8 | 703,383,424.0 | 104,952,506.4 |
| 31 | Хүннү сиэл | 3,083,950.9 | 925,293.3 | 4,576,595.0 | 1,256,119.0 |
| 32 | Цагаан гэрэлт | - | - | 31,078,501.0 | 7,736,760.0 |
| 33 | Эй Эс Ай Би | - | - | 26,207,725.1 | 3,931,158.8 |
| 34 | Эл Би брокерэж | - | - | 80,477,374.0 | 14,920,539.7 |
| 35 | Эм жи ай би | 7,000,000.0 | 1,400,000.0 | - | - |
| 36 | Эрсдэлийн шийдэл | 1,168,364,308.0 | 349,685,561.9 | - | - |
| 37 | Эс ай би эс | - | - | 18,923,547.0 | 2,952,073.0 |
| | Нийт | **13,569,563,826.3** | **1,002,616,800.8** | **5,722,925,833.0** | **914,045,761.8** |

***Тэмдэглэл:***-*үйл ажиллагаа эрхлээгүй болон финад тайлан ирүүлээгүй компани*

## 5.2.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Даатгалын хохирол үнэлэгч 29 компаниас тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл авсан 2 компани, тайлангаа фина системд ирүүлээгүй 6 компаниас бусад 21 компанийн тайлан фина системд нэгтгэгдсэнээс үзэхэд 18 компани даатгалын хохирол үнэлгээний үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан компаниудын тайлангаас нэгтгэхэднийт 2.9 тэрбум төгрөгийн даатгалын хохирлын хэмжээ бүхий6309 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 178.6сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Даатгалын хохирол үнэлгээний орлого нь өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өссөн байна.

| Хүснэгт-15 № | **Компани** | **2015.03.31** | | | **2016.03.31** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Даатгалын хохирлын нийт үнэлгээ | Даатгалын хохирлыг үнэлсэн тоо | Даатгалын хохирол үнэлгээний орлого | Даатгалын хохирлын нийт үнэлгээ | Даатгалын хохирлыг үнэлсэн тоо | Даатгалын хохирол үнэлгээний орлого |
| 1 | Арвижих эстимэйт | 165,456,638.0 | 409 | 7,861,819.0 | 134,705,981.0 | 204 | 5,045,750.0 |
| 2 | Арга билэг эстимэйт | - | - | - | 52,195,591.0 | 147 | 3,881,000.0 |
| 3 | Ашид билгүүн | 328,820,000.0 | 2,068 | 59,100,000.0 | 268,350,489.0 | 2,074 | 83,767,290.0 |
| 4 | Бэст эстимэйт | 21,501,000.0 | 56 | 1,140,000.0 | 123,065,000.0 | 41 | 1,545,206.4 |
| 5 | Вендо | 543,638,339.0 | 1,485 | 33,456,363.6 | 1,205,932,156.4 | 1,323 | 31,939,091.9 |
| 6 | Гэрэгэ эстимэйт | - | - | - | 263,887,386.0 | 494 | 11,577,500.0 |
| 7 | Жи эй си си | 157,165,788.0 | 200 | 4,804,545.5 | 34,659,470.0 | 61 | 1,765,000.0 |
| 8 | Итгэлт эстимэйт | 193,552,493.0 | 276 | 6,232,728.0 | 106,466,416.0 | 122 | 3,401,817.0 |
| 9 | Капитал эстимэйт | 0.0 | 0. | 6,561,000.0 | - | - | - |
| 10 | Кости эстимэйт | - | - | - | 100,640,250.0 | 273 | 5,346,500.0 |
| 11 | Лэндс | - | - | - | 48,039,062.0 | 123 | 2,111,818.2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Мастер Үнэлгээ | 119,167,372.0 | 283 | 7,067,000.0 | 100,561,860.0 | 185 | 5,245,455.0 |
| 13 | Мега марз | 46,035,000.0 | 73 | 1,392,000.0 | - | - | - |
| 14 | Сэлэнгэ эстимэйт | 242,689,429.0 | 519 | 13,479,000.0 | 62,437,010.0 | 105 | 2,948,000.0 |
| 15 | Тэгшсонголт эстимэйт | 12,108,300.0 | 19 | 542,000.0 | 20,305,870.0 | 23 | 658,181.8 |
| 16 | Тэнцвэр эстимэйт | - | - | - | - | - | - |
| 17 | Ухаашүрт консалтинг | 335,875,423.0 | 769 | 12,554,545.0 | 126,257,672.0 | 709 | 5,272,727.0 |
| 18 | Файн эстимэйт | - | - | - | - | - | - |
| 19 | Фэйр валуэшн | 85,649,765.0 | 134 | 3,954,000.0 | 73,048,820.0 | 167 | 4,191,500.0 |
| 20 | Хас үнэлгээ | - | - | - | - | - | - |
| 21 | Хос стандарт | 35,930,000.0 | 95 | 2,360,000.0 | 37,420,000.0 | 93 | 4,785,000.0 |
| 22 | Хөрөнгө үнэлгээний төв | 1,250,000.0 | 3 | 90,000.0 | 1,360,000.0 | 9 | 290,000.0 |
| 23 | Хөрөнгө эстимэйт | - | - | - | 97,200,250.0 | 153 | 4,814,000.0 |
| 24 | Юу Энд Эн | - | - | - | - | - | - |
| 25 | Аа аперейзал | - | - | - | - | - | - |
| 26 | БАНХАС | - | - | - | - | - | - |
| 27 | Виннэрвэй | - | - | - | - | - | - |
| | Нийт | **2,288,839,547.0** | **6,389** | **160,595,001.1** | **2,856,533,283.4** | **6,306** | **178,585,837.3** |

***Тэмдэглэл:-*** *үйл ажиллагаа эрхлээгүй болон финад тайлан ирүүлээгүй компани*

## 6. ДҮГНЭЛТ

Монгол улсын даатгалын салбарын 2016 оны 1 дүгээр улирлын санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгыг эмхэтгэж, салбарын гол үзүүлэлтүүдийг сүүлийн жилүүдийн мөн үеийнүзүүлэлтүүдтэй харьцуулж, дүгнэлээ.

2016 оны 1 дүгээр улиралд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 188.9 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 80.4 хувийг ердийн даатгалын компаниуд, 4.1 хувийг урт хугацааны даатгалын компани, 15.5 хувийг давхар даатгалын компани тус тус эзэлж байна. Нийт хөрөнгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 орчим хувиар өссөн нь сүүлийн 5 жилийн 1 дүгээр улирлаар тооцсон дундаж өсөлтөөс бага байна. 2016 оны 1 дүгээр улирлын байдлаарх даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 23.5 тэрбум төгрөгөөр буурч, өр төлбөр35.3 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 6.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Хорооноос “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж, 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн ердийн даатгалын компаниуд тус журмыг мөрдөж нөөц сангаа байгуулж эхэлсэн эхэлсэн нь даатгагч нарын нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.0 хувиар буурсан үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 27.2 тэрбум төгрөгийн даатгалынхураамжийн нийт орлого төвлөрүүлж, 8.6 тэрбум төгрөгийн нийт нөхөн төлбөр олгосон байна. Салбарын хэмжээнд 2015 оны 2 дугаар улирлаас ажиглагдах болсон гол үзүүлэлтүүдийн өсөлтийн удаашрал нь энэ оны 1 дүгээр улиралд ч ажиглагдаж байгаа бөгөөд даатгалын компаниудын нийт хөрөнгө,хураамжийн нийт орлого,даатгуулагчийн

тоо, нөхөн төлбөр зэрэг салбарын илэрхийлэгч үзүүлэлтүүдийг сүүлийн 5 жилийн 1 дүгээр улиралтай харьцуулахад өмнөх оны мөн үеэс өссөн өсөлт нь 5 жилийн дундаж өсөлтөөс харьцангуй доогуур байна.

Давхар даатгалын болон даатгалын компаниудын тайлант үеийн цэвэр ашиг 3.9 тэрбум төгрөгт хүрч, хуримтлагдсан ашиг 10 тэрбум төгрөг болжээ. Даатгагч нарын ашигт ажиллагаанд гол нөлөөлөх харьцаануудыг тооцож үзвэл салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 8.6 хувь, үндсэн үйл ажиллагааны зардлын харьцаа36.6 хувь, хохирлын харьцаа 42.7 хувь, зардал ба хохирлын хосолсон харьцаа 79 хувьтай байгаа бөгөөд тайлант хугацаанд даатгагч нарын ашигт ажиллагаа өсөхөд хүчтэй нөлөөлж буй нь зардал ба хохирлын хосолсон харьцааны үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд даатгалын хураамжийн нийт орлогын 40 гаруй хувийг даатгалын төлөөлөгч болон даатгалын зуучлагч нар төвлөрүүлжээ. Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд 6306даатгалынхохирлыг үнэлж, 178.6 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын хураамжийн нийт орлого ДНБ-ний 0.58 хувийг эзэлж, нэг хүнд ногдох даатгалын нийт хураамжийн орлого ойролцоогоор 8.9 мянган төгрөг байна. Манай улсын даатгалын салбарын хувьд хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дунджаас харьцангуй доогуур үзүүлэлттэйбайдаг бөгөөдэдгээр үзүүлэлтүүдийн хувьд мөн тодорхой өсөлт ажиглагдахгүй байна.Гэвч эдгээр үзүүлэлтүүдийг жилийн эцсийн тоон мэдээлэлд үндэслэж тооцвол бодитой тооцоолол болох бөгөөд зөв дүгнэлт гаргаж чадах юм. Дараах графикт урьдчилсан дүн буюу явцын мэдээллийг өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан болно.

График-23

**Даатгалын нэвтрэлт, нягтгал**




Салбарын гол үзүүлэлтүүдийн өсөлт өмнөх онуудын мөн үеэс бага өсөлттэй боловч нийт дүнгээрээ өсч, зах зээлийн хамрах хүрээ тэлсээр байна. Нэгдүгээр улирлын нэгтгэлээс салбарыг дүгнэх нь учир дутагдалтай бөгөөд цаашдын чиг хандлагыг таамаглах боломжтой юм. Энэхүү тайлант хугацаа болон өмнөх жилүүдийн статистикаас дүгнэвэл 2016 оны эцэстдаатгалын салбарын гол үзүүлэлтүүдийн дүн 2015 оны эцсээс буурах хандлагатай байна.

ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР